

**ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай**

Говь ХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотой ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Компанийн тухай хуулийн 81-р зүйлийн 81.1, 81.2 дахь заалт, Говь ХК-ийн дүрмийн 6.2-р зүйлийн 6.2.20, 6.2.21 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг Хавсралт-1 ёсоор шинэчлэн томилсугай.
2. Шинээр томилогдсон хороодын дарга, гишүүдэд Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрэм болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:





Д.ГЭРЭЛМАА



Б.АМАРСАЙХАН



Ц.БААТАРСАЙХАН



А.ЖАРГАЛМАА



Н.МӨНХБАТ



Ц.ОРГИЛБОЛД




Д.ХУЛАН



Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2024 оны 10 сарын 30-ны өдрийн хурлын  
34-р тогтоолын 1-р хавсралт



ГОВЬ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН

Хороод		Бүрэлдэхүүн	
Нэр дэвшүүлэх хороо	дарга	хараат бус гишүүн	Д.Хүрэлбаатар
	гишүүн	ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн	Д.Гэрэлмаа
	гишүүн	ердийн гишүүн	Ц.Баатарсайхан
Цалин урамшууллын хороо	дарга	хараат бус гишүүн	Д.Хүрэлбаатар
	гишүүн	хараат бус гишүүн	Б.Цээням
	гишүүн	ердийн гишүүн	Д.Хулан
Эрсдэл, аудитын хороо	дарга	хараат бус гишүүн	А.Жаргалмаа
	гишүүн	ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн	Д.Гэрэлмаа
	гишүүн	ердийн гишүүн	Н.Мөнхбат

2024 он 10 сар 30 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

**Гоёо ХХК-ийн Гүйцэтгэх захирлыг өөрчлөх, томилох тухай**

Говь ХК-ийн Гүйцэтгэх захирлыг шинээр томилох тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76.1.8, 80.7, 84.4.4 дүгээр заалт, Гоёо ХХК-ийн дүрмийн 9.2 дугаар заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Гоёо ХХК-ийн Гүйцэтгэх захирал Батчулуун овогтой Ариунаа-г 2024 оны 10-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болгон өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Гоёо ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар Баатарсайхан овогтой Амарсайханыг 2024 оны 11-р сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.
3. Энэхүү шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн саналын эрхтэй ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.
4. Шинээр томилогдсон Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-тай Менежментийн гэрээний нэмэлт гэрээг байгуулах эрхийг ТУЗ-ийн дарга /Д.Гэрэлмаа/-д олгосугай.
5. Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д Гоёо ХХК-ийн дүрэм болон ТУЗ-ийн даргатай байгуулсан Менежментийн гэрээний хүрээнд компанийг төлөөлж, өдөр тутмын үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн удирдан ажиллахыг үүрэг болгосугай.
6. Гүйцэтгэх захирлын мэдээллийг Улсын бүртгэлд итгэмжлэлгүйгээр төлөөлөн бүртгүүлж компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэхийг Хуулийн хэлтсийн дарга /Ц.Цасчихэр/-т даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ